

## 2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛ ҮЙЛ АЖИЛГААНЫ ТАЙЛАН

Баянгол Зочид буудал нь 360 хүн хүлээн авах, таван ангилалын 212 өрөө, 300-450 хүн хүлээн авах боломжтой Баянгол ресторан, Монголын нэг өдөр ресторан, Ази-Европ хоолны ресторан, дээд зэрэглэлийн виноны Wine House кафе-баар, зочны угаалга, өрөөний үйлчилгээ, үсчин гоо сайхан, интернет зэрэг 20 гаруй төрлийн дагалдах үйлчилгээг зочдод үзүүлж байна.

### ➤ БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ ХК-НИЙ 2017 ОНЫ ЗОРИЛТ

**ЗОРИЛТ:** Зочид гийчдийн тав тухтай орчныг бүрдүүлж MNS ISO чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлж МЭРГЭШСЭН баг хамт олон үйлчлүүлэгч бүрийн сэтгэл нийцсэн шинэлэг үйлчилгээгээрээ буудлын ор ашиглалтыг 3.6%-иар нэмэгдүүлж, татварын өмнөх ашгийг өнгөрсөн оны хэмжээнд байлгана.


### ➤ 2017 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт

Баянгол зочид буудал ХК нь 2017 оны эхний хагас жилд дунджаар үндсэн 170-аад ажиллагсадтай зочны урсгалд тохируулан гэрээт болон улирлын чанартай ажилчид авч ажилуулан, зочин, гийчдэдээ үйлчлэсэн.

2017 оны эхний хагас жилд 260.0 мянга гаруй аялагч, жуулчид манай улсад ирсэн бөгөөд Баянгол зочид буудалд 11.6 мянган зочид байрласан нь зочид буудлын салбарны зах зээлийн 5 орчим хувийг эзэлж байна.

### Компанийн 2016-2017 оны 2 улирал орлого, зардал, ашгийн харьцуулалт

#### 2016-2017 First Half / Income, Expense & Profit



Тайлангийн хугацаанд нийт орлого 2016 оны 2-р улирлаас 3 хувиар, төлөвлөснөөс 12 хувиар тус тус буурсан. Нийт зардал өмнөх оны мөн үеэс 4 хувиар, төлөвлөснөөс 12 хувиар тус тус хэмнэсэн.

Тайлангийн хугацаанд цэвэр ашиг 2016 оны 2-р улирлаас 2 хувиар өсөж, борлуултын орлогын 1 төгрөг тутмаас олох цэвэр ашиг өмнөх оноос 12 хувиар өссөн.

➤ **Ногдол ашиг**

Баянгол Зочид Буудал ХК нь 2017 оны 4-р сарын 27 ний өдөр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал амжилттай зохион байгуулсан

Компанийн ТУЗ-ын хурлаас 2016 оны бизнесийн үйл ажилгаа болон санхүүгийн тайланд дүгнэлт өгч 2016 оны ногдол ашгийн нэгж хувьцаанд 355 төгрөгөөр тооцон 2017 оны 9-р сараас ҮЦГХТ-р болон өөрийн байраар дамжуулан хувиарлахаар шийдвэрлээд байна.

➤ **Компанийн хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн дүн шинжилгээ**

Д/д	САНХҮҮГИЙН ХАРЬЦААНУУД	2016 II	2017 II	2017 / 2016
1	Эргэлтийн харьцаа	3.90	4.05	+4%
2	Түргэн хөрвөх чадварын харьцаа	3.73	3.89	+4.3%
4	Богино хугацааны өр төлбөрийн харьцаа	0.26	0.25	-9%
3	Орлогын нэг төгрөгт ноогдох ашиг	0.16	0.18	+12%

**Эргэлтийн харьцаа:** Зах зээл хөгжсөн орнуудад эргэлтийн харьцаа нь 2/1 буюу өр төлбөрөө эргэлтийн хөрөнгөөрөө 2 дахин түүнээс дээш барагдуулах чадвартай бол зохистой гэж үздэг манай байгууллагын хувьд эргэлтийн харьцаа нь 2016 оны 2 улиралд 3.9 байсан бол 2017 онд 4.05 болж өссөн нь байна.

**Түргэн хөрвөх чадварын харьцаа:** Түргэн хөрвөх чадварын харьцаа нь компани өөрийн эргэлтийн өр төлбөрийг хэдий хугацаанд түргэн барагдуулах боломж байгааг харуулдаг харьцаа юм. Дээрх үзүүлэлт нь 2016 оны 2-р улиралд 3.73 байсан бол 2017 онд 3.89 болж 4.3% аар өссөн сайн үзүүлэлт юм.

**Богино хугацааны өр төлбөрийн харьцаа:** Энэхүү харьцаа нь эргэлтэнд орж байгаа хөрөнгийн хэдэн хувийг богино хугацаанд өр төлбөр буюу гадны эх үүсвэрээс санхүүжүүлсэн байна вэ гэдгийг харуулна. Энэ харьцаа багасах тусам тухайн байгууллагын үйл ажиллагаа сайжирч байгааг илэрхийлнэ. Манай байгууллагын хувьд

2016 онд 26%-ийг БХӨТ эзэлж байсан бол 2017 онд 25%-ийг эзэлж 0.9% аар буурсан дүнтэй гарсан.

**Орлогын нэг төгрөгт ногдох ашиг :** Борлуулалтын орлогын хэдэн хувийг цэвэр ашиг эзэлж байгааг өөрөөр хэлбэл борлуулалтын орлогын 1 төгрөг тутамд хэдэн төгрөгийн цэвэр ашиг ногдож байгааг харуулна. 2016 оны эхний хагас жилд борлуулалтын орлогын 1 төгрөгөөс 16.3 мөнгөний цэвэр ашиг олж байсан бол энэ онд 18.4 мөнгө болж өмнөх оноос 12%-иар өссөн байна.

**Дүгнэлт :** 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн шинжилгээ хийхэд Өмнөх оны мөн үеэс эргэлийн харьцаа 4 хувиар, түргэн хөрвөх чадварын харьцаа 4.3 хувиар, орлогын нэг төгрөгт ногдох ашиг 12 хувиар өсөж; эргэлийн хөрөнгө богино хугцааны өр төлбөрийн харьцаа 0.9 хувиар буурсан сайн үзүүлэлттэй гарсан. Мөн 2017 оны эхний хагас жилийг өмнөх мөн үетэй харьцуулхад компанийн хөрөнгө оруулалтын өгөөж 5 хувиар өссөн бөгөөд , санхүүгийн хүндэрлийн Альтманы Z үнэлгээ нь 3.42 гарсан нь 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн шинжилгээгээр компанийн үйл ажилгааг хэвийн гэж дүгнэж байна.